


БАТЛАВ:
АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГА



Ж.ЦОЛМОН

АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ АНГИЛАХ,
БҮРТГЭХ ЖУРАМ

Баримт бичгийн код	АХОЗШША - 25-05		
Баталсан огноо:	2025 он- 11 сар- 05 өдөр		
Хянасан:	Албан тушаал, нэр Х. Наранхүү	Огноо 2025.11.04	Гарын үсэг
Боловсруулсан:	Албан тушаал, нэр Ч. Буянбадрах	Огноо 2025.11.04	Гарын үсэг

Өөрчлөлтийн бүртгэл

Өөрчлөлтийн дугаар	Өөрчлөлтийн товч тайлбар	Өөрчлөлт оруулах хэсэг	Өөрчлөлт хийсэн ажилтны нэр, албан тушаал	Огноо	Гарын үсэг
				2025. 10.28	

Түгээлтийн жагсаалт

№	Баримт бичиг	Хэнд (түгээх нэгж/байгууллага)
1		
2		
3		

АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ АНГИЛАХ, БҮРТГЭХ ЖУРАМ

1. Зорилго

1.1. Энэ журмын зорилго нь Нислэг /агаарын хөлөг зогсоолоос хөдлөхөөс эхлүүлэн зогсоолд ирж бүрэн зогсох/-ийн үед агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбогдсон осол, зөрчлийг бүртгэх, ангилах ажиллагааг зохицуулахад оршино.

2. Осол, зөрчлийг бүртгэх

2.1. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба “Иргэний нисэхийн тухай” Монгол Улсын хуулийн 42.1-д заасны дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт гарсан агаарын хөлгийн осол, зөрчлийг Конвенцийн 13 дугаар хавсралтын дагуу шинжлэн шалгах, ангилах, бүртгэх ажиллагааг гүйцэтгэнэ.

2.2. Гадаад улсын нутаг дэвсгэрт гарсан Монгол улсын бүртгэлтэй, Монгол улсын тээвэрлэгчийн агаарын хөлгийн осол, зөрчлийг бүртгэнэ.

2.3. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба нь агаарын хөлгийн осол, зөрчлийн мэдээллийг бүх эх үүсвэрүүдээс авах арга хэмжээг зохион байгуулна.

2.4. Осол, зөрчлийн талаарх мэдээллийг зөвхөн шинжлэн шалгах ажиллагаанд болон иргэний нисэхийн аюулгүй ажиллагааг хангуулахад, урьдчилан сэргийлэхэд чиглэгдэнэ.

2.5. Осол, зөрчлийн мэдээллийг шинжлэн шалгагч нар хүлээн авах ба хүлээн авсан шинжлэн шалгагч нь болсон явдлыг тодруулах, урьдчилсан байдлаар зөрчлийг тодорхойлж батлагдсан маягтын дагуу мэдээллийг бүртгэл хариуцсан мэрэгжилтэнд өгнө.

2.6. Бүртгэл хариуцсан мэрэгжилтэн мэдээллийн дагуу осол, зөрчлийг мэдээллийн санд оруулж бүртгэлд авна.

3. Осол, зөрчлийн ангилал

3.1. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжлэн шалгагч нь ирсэн мэдээллийн дагуу осол, зөрчлийг ангилан шинжлэн шалгах чиглэлийг тодорхойлно.

3.2 Агаарын хөлгийн осол, зөрчлийг Чикагогийн Конвенцийн 13 дугаар хавсралтанд заасны дагуу осол, ноцтой зөрчил, зөрчил гэж үндсэн 3 хэсэгт ангилна.

3.2.1. “Осол” Аливаа этгээд нислэг үйлдэх болон зорчих зорилгоор агаарын хөлгийн бүхээгт орсон үеэс эхлэн, агаарын хөлөгт байгаа бүх этгээд хөлгийн бүхээгийг орхих хүртэлх хугацаанд:

3.2.1.1 Хэн нэгэн этгээд дараах нөхцөлд хүнд гэмтэл авах буюу амь насаа алдах :

Тухайн агаарын хөлөгт байх үедээ эсхүл агаарын хөлөгтэй шууд буюу агаарын хөлгөөс салсан хэсэгтэй харьцсаны улмаас эсхүл, сэнст болон тийрэлтэт хөдөлгүүрийн хийн урсгалын нөлөөлөлд орсны улмаас хүнд гэмтэл авах буюу хүнд гэмтэл авсны улмаас амь насаа алдах, сураггүй алга болох.

Тайлбар.1: Биед ердийн шалтгаанаар гэмтэл үүссэн, өөрөө өөрийгөө гэмтээх буюу өрөөл бусдаас гэмтэл авах, эсхүл тийзгүй зорчигч нисэх баг болон зорчигч байрлах ёстой газраас өөр газарт нуугдаж байрласнаас гэмтэл авсан тохиолдлууд хамаарахгүй.

Тайлбар.2: Биеийн хүнд гэмтэл- Агаарын хөлгийн осол, зөрчлийн үед авсан биеийн хүнд гэмтэл, эрүүл мэндэд хортой нөлөөлөл үзүүлсэн болон амь насанд аюул учруулаагүй боловч доорх тохиолдлууд хамрагдана. Үүнд :

а/ гэмтэл авснаас хойш 7 хоногийн дотор 48 цагаас дээш эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн,

б/ бүх төрлийн ясны хугаралт /хөл гарын хуруу, хамрын ердийн хугарал хамаарахгүй/, үе мөчний мултралт, булгаралт, зөөлөн эд анги дарагдах болон дарагдан няцарсан байх,

в/ биеийн гэмтлээс болж цус ихээр алдах, мэдрэлийн судас, булчин, шөрмөс гэмтэх,

г/ биеийн дотоод эрхтэн гэмтэх, дотоод гэмтэл авах, нүдний алим гэмтэх болон хараа муудах,

д/ хими, дулааны нөлөөллөөр түлэгдсэн хэсгээс хамаарахгүй 2, 3-р зэргийн түлэгдэл, 5%-с их биений гадаргуугын болон амьсгалын замын түлэгдэл, ухаан алдалтанд хүргэсэн цахилгаан гүйдэлд цохиулах, амьсгал хүндрэх, 3, 4-р зэргийн хөлдөлт,

е/ радиаци, хорт бодисын болон халдварын нөлөөллөөр болсон нь нотлогдвол,

ж/ тархи, нугас дунд болон хүнд доргилттой, тархины дотор цус хурсан,

з/ үр зулбах болсон,

Тайлбар: Нэгдсэн статистик судалгаанд осол болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор хүнд гэмтлийн улмаас нас барсаныг амь насаа алдсан гэсэн ангилалд хамруулна.

3.2.1.2. Агаарын хөлөг гэмтэл авах буюу түүний их бие бүтэц эвдрэлд орсны улмаас :

Агаарын хөлгийн их бие, үндсэн хийцийн бөх бат чанар болон нислэг-техникийн үзүүлэлт алдагдах :

Их засвар хийх буюу гэмтсэн эд ангийг солих шаардлагатай болсон /Хөдөлгүүр түүний бүрээс /капот/ буюу туслах эд анги, хэрэглэлүүдийн гэмтлийн шалтгаанаас хөдөлгүүр гэмтсэн буюу татгалзах нөхцөл үүссэн буюу сэнс, далавчны үзүүр, антеннууд, пневматикууд, тормозны төхөөрөмжүүд мөн хальтруулагч/обтекатель/-ийн гэмтэл, их биений гадаргууд бага хэмжээний хонхорхой ба цөмөрхий үүссэн зэрэг тохиолдлууд хамаарахгүй/

3.2.1.3. Агаарын хөлөг сураггүй алга болох

3.2.2. **“Ноцтой зөрчил”** гэж осолд хүргэж болох аливаа зөрчлийг хэлнэ. “Ноцтой зөрчил”, “Осол” нь зөвхөн үр дагавраараа ялгагдана. Үүнд:

3.2.2.1. Аюултай ойртолтоос зайлсхийх, мөргөлдөх болон аюулын нөхцөл байдлаас гарах зорилгоор зайлшгүй хийгдсэн маневр, үйл ажиллагаа.

3.2.2.2. Агаарын хөлөг газрын гадаргуу, саадтай мөргөлдөхөөс зайлсхийсэн нөхцөл.

3.2.2.3. Хаалттай болон чөлөөлөгдөөгүй хөөрөлт буултын зурвасаас хөөрөлтийг зогсоох.

3.2.2.4. Хаалттай болон чөлөөлөгдөөгүй хөөрөлт буултын зурвас дээр байгаа саад хүртлэх хамгийн бага зайд хөөрөлт үйлдэх.

3.2.2.5. Хаалттай болон чөлөөлөгдөөгүй хөөрөлт буултын зурвасанд буулт хийх.

3.2.2.6. Гүйлт болон өндөр авалтын эхний шатанд агаарын хөлөг шаардлагатай үзүүлэлтүүдийг авч чадахгүй нь илэрхий болох.

3.2.2.7. Зорчигчийн болон ачааны хэсэгт гал гарах, утаа орж ирэх, хөдөлгүүрт гал гарах /хэдийгээр тэдгээрийн гал унтраах хэрэгслүүдийг ашиглан унтраасан ч гэсэн/ тохиолдолууд.

3.2.2.8. Нисэх баг хүчилтөрөгчийн төхөөрөмжийг ашиглахад хүргэсэн нөхцөл.

3.2.2.9. Агаарын хөлгийн бүтэц болон хөдөлгүүр эвдрэлд орсон.

3.2.2.10. Агаарын хөлгийн нислэгт нөлөөлж болох нэг болон түүнээс дээш систем ажилгүй болох.

3.2.2.11. Нислэгийн үед нисэх багийн гишүүн хөдөлмөрийн чадвараа алдах.

3.2.2.12. Нисэх багаас түлшний хэмжээний талаар аюулын дохио өгөгдөх.

3.2.2.13. Хөөрөлт буултын зурвасыг давах, дутах, хажуу тийш гарах гэх мэт хөөрөлт, буултын үеийн зөрчлүүд.

3.2.2.14. Системийн татгалзал, цаг агаарын үзэгдэлтэй бүсэд орох, нислэгийн өгөгдхүүний хязгаарлалтаас давах зэрэг агаарын хөлгийг удирдахад хүндрэл учруулсан нөхцөлүүд.

3.2.2.15. Нислэгийг удирдах болон навигацийн хяналтын системүүдэд зайлшгүй шаардлагатай нэгээс дээш нөөц систем татгалзах.

3.2.2.16. Агаарын хөлөг нислэгийн үед шувуутай мөргөлдөн аргагүйдсэн буулт хийх.

Тайлбар.1: Ноцтой зөрчлийг энэ жагсаалтаар хязгаарлаж болохгүй бөгөөд өөрчлөлт орж болно.

Тайлбар.2: Агаарын хөлгүүдийн ойртолт- нисэгч болон агаарын хөдөлгөөний үйлчилгээний ажилтнуудын үзэж байгаагаар агаарын хөлгүүдийн хоорондын зай, мөн түүнчлэн тэдний харцангуй байрлал болон хурд нь тэдгээр агаарын хөлгийн аюулгүй байдалд аюул үүссэн нөхцөл юм. Агаарын хөлгийн ойртолтыг доорх байдлаар ангилна. Үүнд :

Ноцтой зөрчил :

Мөргөлдөх аюул тулгарсан- Агаарын хөлгүүдийн мөргөлдөх нөхцөл үүссэн. /Агаарын хөлгүүд хоорондоо ойртохоос сэргийлэх төхөөрөмж/TCAS/-ийн “RA” горим ажиллан аюулыг зайлуулах зорилгоор агаарын хөлгүүдийн зайлшгүй хийгдсэн маневр /

Нислэгийн аюулгүй байдал хангагдаагүй- Агаарын хөлгүүдийн ойртолт тэдгээрийн аюулгүй байдлыг хангаж чадахгүй нөхцөл үүссэн. /“TA” горим ажиллан агаарын хөлгүүд зөвшөөрөгдсөн хэмжээнээс ойр зайд зөрж өнгөрсөнийг бодит хяналтын төхөөрөмж, мэдээлэлийг үндэслэн тогтоосон.

Тайлбар.3: *Агаарын хөлөг газрын гадаргуу, саадтай мөргөлдөхөөс зайлсхийсэн нөхцөл-д* агаарын хөлгийн нислэгийн явцад

3.2.3. **“Зөрчил”** гэж Агаарын хөлгийн ашиглалтын үед түүний аюулгүй ажиллагаанд нөлөөлсөн эсхүл нөлөөлж болохуйц ослоос бусад тохиолдлыг

3.2.3.1. Агаарын хөлгийн зөрчил гэж агаарын хөлгийн ашиглалттай холбогдон гарсан аливаа зөрчлийг.

3.2.3.2. Аэродром дээрхи зөрчил гэж агаарын хөлгийн ашиглалтын үед гарсан дараах зөрчлийг:

а/ аэродромын хаалт хашлага, барилга байгууламж, тэмдэг тэмдэглэгээ зэргийг мөргөж, шүргэснээс.

б/ агаарын хөлгийн явгалах зам, талбайн гадаргуугийн гэмтлээс шалтгаалсан.

в/ аэродром дээрх тоног төхөөрөмжийн гэмтлээс шалтгаалсан.

3.2.3.3. Нислэгийн хөдөлгөөний удирдлагаас шалтгаалсан зөрчил гэж агаарын хөлөг нислэгийн үед нислэгийн хөдөлгөөний удирдлагаас гаргасан алдаатай шийдвэрүүд, үйл ажиллагаа.

3.2.3.4. Шувуунаас шалтгаалсан зөрчил гэж агаарын хөлөг шувуутай хэт ойртсоны улмаас.

3.2.3.5. Аюултай ачаатай холбогдсон зөрчил гэж агаарын хөлгөөр аюултай ачаа тээвэрлэхтэй холбогдсон дараах зөрчлийг:

а/ Аюултай ачааг боож баглах журмыг зөрчсөнөөс хүний бие болон өмч хөрөнгөнд гэмтэл учруулах, шатах, эвдрэх, сэгсрэгдэх болон цацраг идэвхт бодис алдагдах, хортой шингэн бодис асгарах, гоожих.

б/ аюултай ачааг буруу мэдүүлсэн, савласан, буруу шошго зүүсэн болон тэмдэглэсэн, бичиг баримтыг зохих ёсоор бүрдүүлээгүй.

3.2.3.6. Агаарын хөлгүүдийн ойртолтын зөрчил :

- Мөргөлдөх аюул /эрсдэл/ байгаагүй гэж агаарын хөлгүүд ойртсоноор мөргөлдөх нөхцөл бүрдээгүй.

- Мөргөлдөх аюул /эрсдэл/-ыг тодорхойлох боломжгүй байсан гэж агаарын хөлгүүд ойртолцсоны талаарх мэдээлэл хангалтгүй, ирсэн мэдээлэл бие биенээ үгүйсгэсэн байх үед мөргөлдөх аюул тулгарсныг батлах боломжгүй нөхцөл.

3.2.4. **“Онцгой тохиолдол”** гэж агаарын хөлгийн үйл ажиллагаанаас шалтгаалаагүй, нислэг - техникийн осол, зөрчилд хамааралгүй дараах үйл явдал болсноор :

- Агаарын хөлөг дотор санаатай болон санамсаргүй байдлаар өөрийгөө болон өрөөлийн амь насыг хохироох,

- агаарын хөлөгт өөрийн дураар орж нисэх баг болон зорчигч байрлах газраас өөр газарт нуугдаж байх явцдаа хэн нэгэн этгээд амь насаа алдсан бол,

- аэродромын гадна аргагүйдсэн буулт үйлдсэний дараа гаднах орчны тааламжгүй нөлөөгөөр зорчигч, нисэх багийн гишүүдээс хэн нэг нь амь насаа алдах,

- агаарын хөлгийн гадна орших хэн нэгэн этгээд агаарын хөлөг түүний хэсэг болон хөдөлгүүр /сэнс/-ийн хийн /агаар/ урсгалтай харьцсаны улмаас амь насаа алдах болон биеийн хүнд гэмтэл авах,

- агаарын хөлөг газар дээр байгалийн гамшигт өртөх, техник үйлчилгээ, тээвэрлэх, хадгалах горим зөрчигдсөнөөр агаарын хөлгийн хийцийн бат бөх алдагдах, нислэг техникийн өгөгдөхүүн өөрчлөгдөх,

- газарт болон агаарт байгаа агаарын хөлгийг булаах зорилгоор эзэлж авах